



“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04-р сарын 17-ны өдөр

Дугаар ХЭ-26/01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 13:00 цагт ХУД-ийн 20-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав. Хурлыг Булигаар ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Б.Баттүшиг даргалж, Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Нямдорж, Сэрэлт дөл аудит ХХК-ийн төлөөлөгч нар оролцов.

Хурлын дарга Б.Баттүшиг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Булигаар ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал албан ёсоор эхлэх гэж байна. Хурлаа албан ёсоор эхлүүлэхээс өмнө хурлыг албажуулах ёстой бөгөөд ирцийн мэдээллийг Хувьцаа эзэмшигчдэд өгнө үү хэмээн Тооллогын комиссын дарга Д.Энхзулыг индэр дээр урьж байна.

ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга Д.Энхзул: Булигаар ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг мэдээлье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөр тогтоосныг дурдъя.

Бүртгэлийн өдрөөр Булигаар ХК-ийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны тоо 400,212,000 ширхэг байснаас урьдчилан танилцан санал өгөх хэлбэрээр 156,630,000 саналын эрхтэй 1 хувьцаа эзэмшигч, өнөөдрийн хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр нийт 352,634,224 ширхэг саналын эрхтэй 13 хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт ирц **88.11** хувь болсноор Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирц бүрдсэнийг мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Хурлын дарга Б.Баттүшиг: Тооллогын комиссын дарга Д.Энхзулдаа баярлалаа, хурлын ирц маань хуулийн дагуу бүрдсэн байна, манай хувьцаа эзэмшигчдийн хуралд цаг заваа гарган ирсэн нийт хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн эрхэм гишүүд та бүхэндээ баярлалаа, одоо та бүхэндээ хурлын дэгийг товч танилцуулахад:

- Хурлын ирцийг бүртгэх
- Хурлын ирцийг мэдээлэх
- Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэг танилцуулах
- Үүний дараа хурлаар хэлэлцэх гол гол асуудлуудыг дэлгэцэн дээр слайд хэлбэрээр та бүхэнд танилцуулах, мэдээлэх байгаа мөн та бүхэнд тарааж өгсөн байгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал дээр дэлгэцэн дээр гарч буй бүх мэдээллийг хэвлэмэл байдлаар а4 форматаар та бүхний гарт очсон байгаа мөн жижигхэн брошурын урд байгаа QR кодыг уншуулах юм бол утсан дээрээ дижитал хэлбэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг илүү томруулж харж болно.

- Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуултад хариулт явагдана.
- Санал хураалт явагдана.
- Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгээд үр дүнгээ танилцуулна.
- Хурлаас гарах шийдвэрүүдийг тогтоол болгож та бүхэнд танилцуулаад хурал албан ёсоор дуусах юм.

Хурлаар хэлэлцэх, танилцуулах асуудлыг та бүхэнд танилцуулъя. Бид энэхүү хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн танилцуулж, 3-н асуудал дээр санал авч шийдвэр гаргах байгаа.

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулна.
2. Компанийн тайлант оны ашигт ажиллагаанаас Хувьцаа эзэмшигчдэд Ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулна.
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах;
5. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох талаар мэдээллийг та бүхэнд хүргэж санал хураалтаар шийдвэр гарна.

ХЭЛЭЛЦЭХ, ТАНИЛЦУУЛАХ АСУУДЛУУД:

Нэг. Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах.

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Өнөөдрийн хурлаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлуудын эхний асуудал бол Булигаар ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах юм. 2024 оны гүйцэтгэлтэй харьцуулсан гол үйл ажиллагааны үр дүнг дэлгэцэд харуулсан байгаа. Борлуулалтын орлого 8.99 тэрбум төгрөг болж өмнөх тайлант үеэс 4.2%-аар өссөн үзүүлэлттэй харагдаж байна. 2024 онд борлуулалтын орлогын 20 хувийг эзэлж байсан экспортын орлого маань 0 хувь болсон бид бүх нөөц бололцоогоороо дотоодын бүтээгдэхүүн дээрээ төвлөрч ажилласан. Цэвэр ашиг 302.9 сая төгрөг байна, дотоодын борлуулалт нь 8.99 тэрбум төгрөг буюу өмнөх оны тайлант үеэс 22% өсөлттэй гарсан байна. Энэхүү үзүүлэлт маань юуг хэлж илэрхийлж байна вэ гэхээр манай улсад дотоодын гутлын үйлдвэрлэл болон бусад арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл сэргэн мандаж, хөгжиж байгааг харуулж байна. Бодын арьсны дундаж талбайн хэмжээ 245.7 дм.кв хэмжээтэй үхрийн арьсыг бид боловсруулсан байна. Манай компани нь голчлон үхрийн ширийг гол түүхий эдээ болгон ажилладаг. 160,000 гаран малчин өрхийнхөө бид бүхний махны хэрэгцээнд зориулсан мах бэлтгэлийн салбараас гарч буй үхрийн ширийг бид бүхэн эцсийн шатанд боловсруулж цааш цаашдаа үйлдвэрүүдэд нийлүүлдэг. Үхрийн ширний хувьд дундаж дм.кв буюу дундаж талбайн хэмжээ нь манай үйлдвэрийн гол нөлөөлөх хүчин зүйл болдог байгаа. За үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дундаж үнэ 501.29 төгрөг байна. Борлуулалтын орлогыг 2023, 2024 онтой харьцуулсан байна. 2023 онд 7.2 тэрбум, 2024 онд 8.6 тэрбум, 2025 онд 8.99 тэрбум борлуулалтын орлогыг хийсэн байна. Экспортын орлого 2024 онд 1.4 тэрбум байсан бол 2025 онд экспорт хийгээгүй байна. Манай үйлдвэрийн болон манай улсын арьс ширний салбарын гол эрэлтийг үүсгэдэг БНТУ, БНХАУ, Итали улсуудад мөн арьс ширний салбар

төдийлөн сайн биш ажилласны улмаас, түүнчлэн манай Монгол улсаас бэлтгэн нийлүүлэгдэж байгаа дотоодын түүхий эдийн чанар шаардлага дэлхийн стандартад хүрэхгүй байгаа учраас экспортын борлуулалт унасан байна. Бид бүхэн энэхүү нөхцөл байдалтай уялдуулж дотоодын зах зээл дээрээ илүү төвлөрч ажилласан. 2026 онд бид бүхэн буцаад экспортоо сэргээж хуучны түншүүдтэйгээ хамтарч ажиллан 1.0 тэрбум төгрөгийн экспорт хийх зорилго тавин ажиллаж байна. Цэвэр ашиг, алдагдал, нийт хөрөнгийн талаарх графикайг харуулж байна. 2025 онд цэвэр ашгийн хувьд 302.9 сая төгрөг хүрсэн, нийт хөрөнгийн хэмжээ 35.3 тэрбум төгрөг хүрсэн байна. Үүнийг юутай холбож тайлбарлах вэ гэхээр 2025 оны 04 дүгээр сард манай компани Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан Цагаан алт үндэсний хөтөлбөрөөс хөнгөлөлттэй зээлд хамрагдаж 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан байгаа, тухайн авсан зээл санхүүжилтээрээ үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологи, үндсэн хөрөнгөд сайжруулалт нэмэлт худалдан авалтуудыг хийснээр үндсэн хөрөнгийн хэмжээ өссөн байна. Нийт хөрөнгийн задаргааг харуулбал 2024 онд үндсэн хөрөнгө 17.3 тэрбум төгрөг байсан бол 18.07 тэрбум төгрөг болж өссөн байна, 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн ч санхүү балансынхаа хүчин төгөлдөр хууль журмын дагуу элэгдэл хорогдол тооцож явдаг. Авлагын хувьд 9.1 тэрбум төгрөг байсан бол 11.1 тэрбум төгрөг болж өссөн байна. Анхан шатны үйлдвэрлэлийн тоо хэмжээ нь манай үйлдвэрлэл хэрхэн тогтвортой явж байгааг илэрхийлэх нэг чухал үзүүлэлт байгаа. 2024 онд 95,350 ширхэг үхрийн шир боловсруулсан бол 2025 онд 113,521 ширхэг үхрийн шир боловсруулсан байна. Монгол улсад статистик тоон үзүүлэлтээр жилдээ 800,000 гаруй ширхэг тоо толгой үхэр дотоодын болон экспортын хэрэгцээнд зориулж нядлагдаж байгаа. Манай арьс ширний холбооны албан бус тоон судалгаагаар 300,000 гаруй ширхэг нь арьс ширний салбарт орж хагас бэлэн бүтээгдэхүүн болж явж байна. Манай үйлдвэр нь Монгол улсад төвлөрч буй нийт үхрийн ширэн түүхий эдийн 40-50 хувийг нь авч эцсийн шатанд боловсруулж байна. 2024 онд 267,811 ширхэг ямааны арьс боловсруулсан бол 2025 онд 10,000 ширхэг ямааны арьс боловсруулсан байна. Үйлдвэрлэлийн тоо хэмжээ нь дм.кв-аар хэмжигддэг байгаа, 2024 онд 16 сая дм.кв байсан бол 2025 онд 21 сая дм.кв арьсыг эцсийн шатанд боловсруулсан байгаа нь өмнөх оноос 28.7 хувиар өссөн байна. Дм.кв-ын дундаж үнэ 2024 онд 471.4 төгрөг байсан бол 2025 онд 501.9 төгрөг болж 6.3 хувиар өссөн байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоон үзүүлэлтийг сар сараар нь харуулсан байгаа. 1,2-р сард дундаж үнэ 550, 538 төгрөг байгаа нь юутай холбоотой байгаа вэ гэхээр бидний уламжлалт баяр Цагаан сартай холбоотойгоор хромон гутлын эрэлт хэрэгцээ өсөж үүнийг дагаад хромон арьс ихээр үйлдвэрлэгдэж мөн борлуулагдсантай холбоотой. Үр ашгийн тооцоо нь цэвэр үйлдвэрлэлийн менежменттэй холбоотой, нийт ажиллах хүч юунд төвлөрч ажиллаж байна, ямар бүтээгдэхүүн хийж байна гэдгийг харуулах хүснэгт. Нэг ширхэг арьс ширийг боловсруулахад гарч буй нийт өртөг зардлын 20 хувь нь хөдөлмөрийн зардал байна гэж үзээд байгаа. Нэг хүн/цагт ногдох өртөг нь 2025 онд 15,292 төгрөг, хүн/цагт ногдох үйлдвэрлэл 78,044.34 төгрөг байсан байна. Дм.кв-д ногдох хэрэглээний зардал гэж байна, манай үйлдвэрт үндсэн 4 том байгалийн нөөцийн хэрэглээ байгаа. Манай үйлдвэр нь Хан-Уул дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт суурьшлын бүсэд байрлаж байгаа онцлогтой, бид бохир усыг үйлдвэрийн дэргэдэх цэвэрлэх байгууламжид цэвэршүүлээд дараагийн шатны цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг байгаа. Цэвэр усыг авч ашиглаад бохир усыг хаяж байна,

уурын хэрэглээ, эрчим хүч тог, дулааны хэрэглээ байгаа. Энэ 4 хэрэглээг тооцож үзээд дм.кв-д ногдох хэрэглээний зардлыг гаргасан байгаа. 2025 онд 50.8 төгрөг байсан байна, энэ үзүүлэлтийг 2026 онд 44 төгрөг болгож бууруулах зорилго тавин ажиллаж байна. Үйлдвэрлэл ба борлуулалтын тоо хэмжээний хувьд 2024 онд 16,344,988 дм.кв арьс үйлдвэрлээд 16,947,957 дм.кв арьс борлуулсан байгаа нь 2023 оны үйлдвэрлэсэн арьсны үлдэгдлээс борлуулсан байна гэсэн үг үйлдвэрлэл нь арай бага борлуулалт нь арай их байна, бид бүхэн үүн дээр анализ хийгээд боловсруулах арьсны тоо хэмжээгээ нэмэх хэрэгтэй гэж үзээд 2025 онд 21.4 сая дм.кв арьс үйлдвэрлэж 19 сая дм.кв арьс борлуулсан байна. Монгол улсад албан бус тоогоор жилд 1 сая ширхэг хос гутал үйлдвэрлэгдэж байна гэсэн тооцоо байна, 1 хос гутлын дундаж дм.кв-ыг 45 гэж бодвол Монгол улсад 45 сая дм.кв гутлын арьсны хэрэгцээ байна гэж харагдаж байна. Манай үйлдвэр нь энэ 45 сая дм.кв арьсны 19 сая дм.кв-ыг нь 2025 онд үйлдвэрлээд борлуулсан байна, энэ тоог цаашдаа дахин өсгөх зах зээлийнхээ 50-60 хувь магадгүй 70 хувь хүртэл нь яаж өсгөх талаас нь дунд хугацааны бодлого зорилтуудыг тавиад ажиллаж байна. Бид нартай өрсөлдөж буй хамгийн том бүтээгдэхүүн бол импортын бүтээгдэхүүн байна. Бид нарын 2 том хөрш болох БНХАУ, ОХУ-аас бараа бүтээгдэхүүн болон боловсруулсан арьс манай зах зээл дээр нийлүүлэгдэж байна. Хөрөнгө оруулалтын тухайд бид нар 2024 онд 653.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бол 2025 онд 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Цааш нь задлаад үзэх юм бол түрүүн хэлсэн цагаан алт хөтөлбөрийн хүрээнд авсан зээлийнхээ хүрээнд бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлд хөрөнгө оруулалтуудыг хийсэн. Эхний төхөөрөмж бол индүү сунгах машиныг Итали улсаас 2025 оны 10 сард оруулж ирж суурилуулсан байгаа, дараагийн төхөөрөмж бол хусах дамжлагын зоргодос дамжуургын систем байна. Өмнө нь хусахаас гарч буй зоргодсыг гараар зөөж хаядаг байсан бол энэхүү төхөөрөмжийн тусламжтайгаар хүний оролцоог халж автоматжуулсан. БНХАУ-ын Yancheng Shibao компаниас 20 тонн түүхий эд ачаалах хүчин чадал бүхий 2 ширхэг даацын барбан суурилуулсан. Энэ барбаны ач холбогдол нь бол уламжлалт барбануудаас илүү их арьс ачаална гэсэн үг. Өмнөх барбанууд 8 тонн арьс ачаалах хүчин чадалтай байсан бол энэхүү барбан байна 20 тонныг ачаалах чадалтай. Бүх төрлийн байгалийн нөөцийг хэмнэж, хөдөлмөрийн бүтээмжийг өсгөж байна. Энэхүү барбантайгаа уялдуулаад дамжлагын системийг суулгаж өгсөн дамжлагаас гарсан арьс маань дараагийн халимлах болон хуваах дамжлага дээр очихдоо хүний оролцоогүйгээр очно гэсэн үг. Үс шүүх болон химийн агууламж өндөртэй усыг дахин ашиглах системийг суурилуулсан. Эдийн засгийн өгөөж талаасаа, байгаль орчны бохирдол талаасаа асар өндөр үр өгөөжтэй хөрөнгө оруулалт болсон. Онцлох үйл ажиллагааны талаар: 2025 оны 1 сард Монгол Улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүх БНТУ-д албан ёсны айлчлал хийсэн, энэхүү айлчлалын бүрэлдэхүүнд “Булигаар” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Б.Анхболд болон Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг миний бие оролцож 2 улсын арьс ширний салбарын оролцоог ойртуулах, бизнесийн багтаамжийг нэмэгдүүлэх, туршлага судлах зорилгоор явсан байгаа. Маш өндөр үр дүн авчирсан уулзалт болсон, манай үйлдвэрийн хувьд БНТУ-тай экспорт болон импортын хувьд өндөр ач холбогдолтой ажилладаг. Арьс ширнийг үйлдвэрлэхэд ашиглаж буй голлох машин төхөөрөмж болох химийн бодисыг бид БНТУ-аас импортолж авдаг байгаа. БНТУ-ын СІНАН КІМҮА болон ХБНГУ-ын GREIBO CHEME хэмээх олон жилийн түүхтэй арьс ширний химийн бодис үйлдвэрлэдэг

компанийн арьс ширний мэргэжилтнийг урьж авчран Монголын арьс ширний салбарын бусад үйлдвэрийн технологич нар хамтран Монгол арьсан дээр тохирсон Герман химийн бодисын туршилтыг хийж хүүхдийн гутлын арьсыг үйлдвэрлэх чиглэлд тодорхой үр дүн гаргаад Арьс ширний холбоо болох Хөдөө аж ахуйн яамтай хамтраад одоо болтол хийгээд явж байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд Нийт ажилтнуудын эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулдаг мөн ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд СХД-ийн 21-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Инчон Мөрөөдлийн төгөл цэцэрлэгт хүрээлэнд 100 ширхэг мод тарьсан байна.

Хоёр. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах

Хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах болсон байна. Сэрэлт дөл аудит ХХК-ийн захирал Д.Алтанцэцэг таныг урьж байна.

“Сэрэлт дөл аудит” ХХК-ийн захирал Д.Алтанцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Манай компани нь Булигаар ХК-ийн санхүүгийн тайланг хараат бусаар аудитлах ажлыг сүүлийн 3 жил дараалан хийж байна, хуулиараа 5 жил хийх ёстой. 2025 оны санхүүгийн тайланд хараат бус аудит хийсэн ажлыг товчхон танилцуулъя. Бид Булигаар ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүү байдлын тайлан жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ. Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам СЗХ-ноос гаргасан заавар журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн байгаа. Ямар нэгэн зөрчил 2025 онд байхгүй байна гэж үзлээ. Бид санхүүгийн тайлан гаргахдаа үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулж харсан. Жишээлбэл авлага 2024,2025 онтой харьцуулахад 15.8 хувиар өссөн, дансны өглөг 59.4 хувиар буурсан байна. Үйл ажиллагаагаа сайжруулах, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөмж өгсөн байгаа. Санхүүгийн үйл ажиллагаа нь санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу явж байгаа боловч ашигт нөлөөлөхгүйгээр үйл ажиллагаанд тодорхой хэмжээн нөлөөлж болзошгүй гэсэн дүгнэлт байгаа. Яагаад вэ гэхээр авлага нэлээн өссөн байгаа өнөөдрийн байдлаар 11 тэрбум төгрөгийн авлага үүссэн байна. Авлагаа маш хурдан барагдуулах, хэнээс хэдэн төгрөгийн авлагатай гэдгээ баталгаажуулах, авлагын насжилтыг тодорхойлох хэрэгтэй. Авлагаа хурдан хугацаанд барагдуулбал үндсэн хөрөнгийн эргэлт сайжирна гэсэн дүгнэлтийг өгч байгаа. Аудитын дэлгэрэнгүй дүгнэлтийг тарааж өгсөн материалаас танилцах боломжтой байгаа. Та бүхэндээ баярлалаа.

**Гурав. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан
дүгнэлтийг хэлэлцэн батлах**

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: “Булигаар” ХК-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг танилцуулж өгнө үү хэмээн Хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ч.Нямдорж таныг урьж байна.

Хараат бус гишүүн Ч.Нямдорж: Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлтийг танилцуулъя. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3, 81 дүгээр зүйлийн 81.4.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Булигаар” хувьцаат компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос **ДҮГНЭХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хэлэлцэн цаашид компанийн бизнесийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг уялдуулан “**Хангалттай**” гэж дүгнэн ТУЗ-н хурлаар оруулан ХЭХ-д танилцуулахыг зөвлөсүгэй.

Хоёр. Энэхүү дүгнэлтийн Нэгдүгээр хавсралт дахь дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсугай.

Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, Булигаар ХК-ийн дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

ТУЗ нь өнгөрсөн оны ээлжит хурал дээр тус компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтыг хэлэлцэн баталж, хэрэгжилт дээр компанийн дүрэм, журамд заасны дагуу тогтмол хяналтыг тавин, компанийн Гүйцэтгэх удирдлагын багийг санал зөвлөмж, үүрэг даалгавраар ханган чиглүүлж ажилласан бөгөөд Гүйцэтгэх удирдлагын баг нь ТУЗ-өөс баталсан төлөвлөгөө зорилт, шийдвэр, санал зөвлөмж, үүрэг даалгаврыг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

ТУЗ-ийн баталсан 2025 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилт нь компанийн борлуулалтын орлогыг өмнөх оноос өсгөх, ашигт ажиллагааг сайжруулан ашгийн түвшинг нэмэгдүүлэх, дотоод борлуулалтын сувгийг нэмэгдүүлэн харилцагчид илүү ойртож ажиллах, хүний нөөцийн тогтвортой бодлогыг баримтлан ажиллах, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг сайжруулах зэрэгт тус тус чиглэсэн.

2025 онд санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн хувьд 13 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй ажилласан бол бодит гүйцэтгэлээр 8,991.4 сая /9,890.1 сая ₮ НӨАТ-тэй/ төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөө 76%-ийн биелэлтэй ажиллаж, борлуулалтын орлого өмнөх оноос 4.2%-иар өссөн байна.

2025 онд нийт 1,735 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 96.8%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 3.2%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалтад зарцуулсан байна.

Хүний нөөцийн тогтвортой бодлого барих, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг сайжруулах зорилгоор бүтэц, орон тоог тогтвортой барьж, үйлдвэрлэлийн бүтээл, гүйцэтгэлд суурилсан цалин хөлс, урамшууллын бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж

ажилласан. 2025 онд бодын арьсны хувьд нийт үйлдвэрлэл 19%-иар өсөж, дундаж талбайн хэмжээ 2024 онд 223.6 дм.кв байсан бол 2025 онд 245.7дм.кв бол 9.9 хувиар тус тус өссөн байна. Эдгээр үзүүлэлтүүд нь компанийн үйл ажиллагааны ашигт ажлын эффициент өсөж буйн илэрхийлэл гэж дүгнэж байна.

Гүйцэтгэх удирдлагын баг 2025 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн бүхий л нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, хэтийн зорилгодоо хүрэх, компанийн хөгжлийг урагшлуулах алхмуудыг хийж, бизнесийн орчны өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд зах зээл, орчин нөхцөлд зохицсон үйл ажиллагааг явуулж ажилласан байна. Иймд “Булигаар” хувьцаат компанийн ТУЗ-ийн зүгээс 2025 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд “**Хангалттай**” гэсэн дүгнэлт өгч байна.

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: ТУЗ-ийн 2026 оны 02 сарын 13-ны өдрийн 01/26 тоот тогтоолыг танилцуулъя.

**Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланд дүгнэлт гаргах,
Хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дах заалтуудыг тус тус удирдлага болгон Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг “**Хангалттай**” гэж дүгнэсүгэй.
- Хоёр. Энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралт дахь ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

**Дөрөв. 2025 онд ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн
гаргасан тогтоолыг танилцуулах**

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: 2025 оны ногдол ашгийн тухай Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тогтоолыг та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, “Булигаар хувьцаат компанийн дүрэм”-ийн 10 дугаар зүйлийн 10.5, Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. “Булигаар” ХК нь 2025 оны санхүүгийн жилийн ашигт ажиллагаа зорилтод түвшинд хүрээгүй, Ногдол ашиг төлсний дараа компанийн төлбөрийн чадварт нөлөөлж болзошгүй тул Булигаар ХК-ийн ногдол ашгийн бодлогын 2.2. дахь хэсгийн 2.2.1. дэх заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

Хоёр. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-д даалгасугай

Ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг тарааж өгсөн материалаас танилцах боломжтой байгаа.

Тав. Компанийн засаглалын кодексын хэрэгжилт, үнэлгээ

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Одоо та бүхэндээ компанийн засаглалын тухай мэдээллийг хүргэе. Компанийн засаглалын кодексыг тогтмол үнэлж явдаг. Манай компанийн хувьд 2024 оны жилийн эцсийн байдлаар 91.7 хувьтай үнэлэгдсэн, 2025 оны хувьд жилийн эцсийн кодексын үнэлгээ хараахан гараагүй байна, 2025 оны хагас жилийн байдлаар 93.1%-ийн гүйцэтгэлтэй гарч Монголын хөрөнгийн биржэд бүртгэлтэй компаниудын 5-р байранд жагссан байна. Кодексыг үнэлсэн үзүүлэлтүүдийг та бүхэнд задалж харуулсан байна, ТУЗ-ийн бүтэц зохион байгуулалт 91.7%, хороодын чиг үүрэг 100%, тайлагнал мэдээллийн ил тод байдал дээр хамгийн бага оноо авч бусад дундаж үзүүлэлтийг доош нь унагаасан байгааг та бүхэн харж байна. Энэ дээр гүйцэтгэх удирдлагын багаас ямар арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бэ гэхээр мэдээллийн ил тод байдлыг олон нийтэд мэдээллэж байхын тулд компани өөрийн цахим хуудас вэб сайтыг www.buligaar.mn гэсэн домайн хаягтайгаар 2026 оны 1-р сард ачааллаж эхэлсэн байгаа. Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилал гэж байгаа. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025.09.25-ны өдрийн А/358 тоот тушаалаар хувьцаат компаниудын 2024,2025 оны үзүүлэлтийг харгалзан үнэт цаасны ангиллыг шинэчлэн тогтооход “Булигаар” ХК нь III ангилалаас II ангилал руу дэвшсэн байна. Энэ бол цэвэр компанийн мэдээллийн ил тод байдал, засаглал, Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд илгээж байгаа тайлангуудын үр дүн байгаа. 1-р ангилалд 25, 2-р ангилалд 43, 3-р ангилалд 94 компани байна.

Зургаа. ТУЗ-ийн үйл ажиллагааны товч тайланг танилцуулах

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Төлөөлөн удирдах зөвлөл нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд 3 удаагийн хуралдаанаар 5 тогтоол, 3 тэмдэглэлээр шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. ТУЗ-ийн хурлыг танхим болон цахим, эчнээ хосолсон хэлбэрээр зохион байгууллаа.

2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд зардлыг 2025 онд 18,221,700 сая төгрөгийн зардал гаргахаар 2025 оны 4 сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар төсөв баталсан. Гүйцэтгэл нь 12 сая төгрөг буюу 68%-ийн зарцуулалтаар гүйцэтгэл хийгдсэн. Энд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, ХЭХ-ын зардал буюу ХЭХ хуралдуулах хурлын зар мэдээг хүргэх, түгээх, зохион байгуулахтай холбоотой зардал, бусад зардал нь үйлчилгээний хураамж. Үйлчилгээний хураамж гэдэгт юу байдаг вэ гэхээр Монголын хөрөнгийн бирж гишүүнчлэлтэй ХК-ийн бүртгэлийн хураамж, Үнэт цаасны төвлөрсөн халамжийн төвд Булигаар ХК-ийн хувьцааг хадгалж гэрээгээр хадгалдаг. Тэрний хадгалалтын жилийн хураамж, бусад үйлчилгээний хураамжууд орсон байгаа. Зардлыг төлөвлөгөө болон гүйцэтгэлээрээ энэ хуудсанд слайд дээр байж байна. Та бүхэнд тарааж өгсөн хурлын материал дээр бас байгаа.

2 дахь асуудал нь бол өнөөдөр хэлэлцэх асуудал. 2026 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг энэ хүснэгтээр та бүхэнд хувьцаа эзэмшигчид танилцуулж байгаа юм. 1 дүгээрт эхний асуудал бол ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын асуудал. Дараагийнх нь болохоор хуралдааныг зохион байгуулах явцад гарч байгаа бичиг хэргийн зардал болон хураамжийн зардлууд бүгд орсон байгаа. 2026 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг 17,121,700 сая төгрөгийн төсөвтэй байхаар ХЭ-ийн хуралд оруулж байна.

Долоо. Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга.

Хурлын дарга Б.Баттүшиг: Гуравдугаар хэлэлцэх асуудал бол Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдээ түрүү жилийн сонгогдсон ТУЗ-ийн гишүүдээ үргэлжлүүлэн сунгаад ажиллуулъя гээд санал оруулж байгаа юмаа. Тарааж өгсөн материалд нэр дэвшигчдийн анкет танилцуулгыг оруулсан байгаа. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн нэрсийг танилцуулахад:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид

1. Төмөрбаатар овогтой Болд
2. Чулуунбаатар овогтой Нямдорж
3. Жадамба овогтой Эрдэнэбат

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчид

4. Батчулуун овогтой Анхболд
5. Батчулуун овогтой Баянжаргал
6. Анхболд овогтой Энхмэнд
7. Довжид овогтой Гансүх
8. Бямбабаяр овогтой Баттүшиг
9. Цэрэндагва овогтой Мөнхлхагва эдгээр хүмүүс нэр дэвшиж байна.

Эдгээр нэр дэвшигчдээс асуух зүйл байна уу.

Та бүхний материал дээр байгаа хурлаас гарах түрүүн би хурлын эхэнд хэлсэн 3 асуудлыг бид нар хэлэлцэж байгаа. 1 дүгээрт 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай, 2 дугаар тогтоолд ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах, 3 дугаар тогтоолд ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай тухай байгаа.

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг: Нийт хэдэн хувьцаа эзэмшигчтэй вэ?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Манай компани нь нийт 931 хувьцаа эзэмшигчтэй байна.

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг: 11 тэрбум төгрөгний авлага тодорхойгүй байна гэж яригдаад байна.

Хараат бус гишүүн Ч.Нямдорж: Бид авлагатай холбоотой авлага өглөгийн насжилтаар нь ангилах талаар зөвлөмж заавар өгөөд хамтран ажиллаж байгаа. 11 тэрбум төгрөгний асуудал нилээн эртнээс үүссэн байгаа, анх компани байгуулагдсанаас эхлэлтэй, үүнийг бид нар шууд байхгүй болгож болохгүй яваад байгаа. Өмнөх ХЭ-ийн үед тодорхой хэмжээнд хамаарал бүхий этгээдүүдэд хамаарах зүйлсийг тодорхой хэмжээнд бичиг

баримт бүрдүүлээд барагдуулаад явж байгаа. Аудитын хорооны дүгнэлт дээр насжилтын хувьд ангилагдахгүй байна гэдэг нь юутай холбоотой вэ гэхээр хэзээ үүссэн нь тодорхойгүй юмнууд байгаа. Сүүлийн үйлдвэрлэлийн процесс дунд авлага өсч байгаа. Гадаад борлуулалтын хувьд төлбөр нь шууд ороод ирдэггүй тодорхой хэмжээнд хугацаа шаардана, дотоод борлуулалтын хувьд жижиг үйлдвэрүүд маань шууд мөнгөө төлөөд авах боломж нь муу байгаа учраас тодорхой хэмжээнд авлагууд үүсч байгаа. Нөгөө талдаа түүхий эд бэлтгэлийн хувьд авлага үүсч байгаа. Насжилтын хувьд ангилаад цэгцлээ гээд ажлын хэсэг тавиад төлөвлөгөө гаргаад ажиллаад явж байна.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Арьс ширний үйлдвэрүүд эмээлт рүү нүүнэ гэсэн асуудлын талаар мэдээлэл өгөөч.

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Нийслэлийн засаг даргын Тамгын газраас энэ ажлыг гардан зохион байгуулаад хийж байгаа. Ажлын явцын талаар өөрийнхөө хэмжээнд мэдээлэл өгье. Манай үйлдвэрийн хувьд нүүнэ гэсэн чиглэлтэй газраа аваад, гэрээгээ хийчихсэн, үйлдвэрийн шинэ барилгын зураг төслийг гаргаад ажиллаад явж байна. Дэд бүтцийн талаар мэдээлэл хүргэхэд 2025 оны 3-р улиралд тендер нь зарлагдаж үндсэн дулааны цахилгаан станц болон цэвэрлэх байгууламжыг бариж гүйцэтгэх компани шалгарч одоо зураг төслийн ажил дээрээ явж байгаа гэсэн. Бид нарыг 2029 оны 1-р улиралд Эмээлтэд нүүж очно гэдэг тал дээр бусад яам газрууд хамтраад ажиллаж байгаа.

Хурлын дарга Б.Баттүшиг: Саналын хуудас тараагдсан байгаа. Санал хураалт явагдах гэж байна.

Тооллогын комиссын дарга Д.Энхзул: Саналын хуудас дээр хэлэлцэх 1, 2 дахь асуудлаар санал өгөхдөө ердийн журмаар нэмэх тэмдэг болон зөвлөх тэмдэглэгээ хийж саналаа өгнө. Дараагийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлын хүрээнд 9 гишүүнийг кумулятив аргаар сонгогдох байгаа, 9 гишүүний тоог таны эзэмшиж буй хувьцааны тоогоор үржүүлээд 3 дахь хэлэлцэх асуудалд өгөх саналын нийт тоо гарч ирнэ. Кумулятив аргаар яаж санал өгөх талаар саналын хуудасны арын хуудас дээрх 6 дугаарт тайлбарласан байгаа. Саналын эрхтэй нийт тоог аль нэг гишүүдэд хувааж өгөх маягаар эсвэл нэг гишүүнд өөрийн саналын өгөх боломжтой байгаа.

САНАЛ ХУРААЛТ:

Санал хураалт 5 минут үргэлжлэв. 10 минут түр завсарлав. Тооллогын комисс саналыг хураалтын дүнг нэгтгэв.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ:

Хурлын дарга Б.Баттүшиг: Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал асуулгын тооллогын дүнг танилцуулахад бэлэн боллоо. Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

Санал хураалтын дүнгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, Булигаар ХК-ийн 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Санал хураалтаар 88.11 хувийн саналын эрхтэй 352,629,224 ширхэг хувьцааны 13 ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.
- Хоёр. Компанийн байранд 39.14 хувийн саналын эрхтэй 156,630,000 ширхэг хувьцааны 1 ширхэг саналын хуудас ирүүлснийг дурдсугай.
- Гурав. Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхоор буюу 99.99 хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

<i>Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн саналын тоо</i>					
Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,630,100	99.99631%	13,000	0.00369%	0	0%

- Дөрөв. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшуулал, зардлын төсөв батлах тухай хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхоор буюу 99.99 хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

<i>Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн саналын тоо</i>					
Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,630,000	99.99629%	13,100	0.00371%	0	0%

- Тав. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлыг кумулятив аргаар 352,643,100 ширхэг хувьцаатай 8 хувьцаа эзэмшигчийн саналаар дараах нэр дэвшигчид нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд сонгогдсоныг мэдэгдсүгэй.

Хараат бус гишүүдэд:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Төмөрбаатарын Болд	88.11%	352,629,300
2	Чулуунбаатарын Нямдорж	88.11%	352,638,300
3	Жадамбын Эрдэнэбат	88.11%	352,629,300

Ердийн гишүүдэд:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Батчулууны Анхболд	88.11%	352,629,000
2	Батчулууны Баянжаргал	88.11%	352,629,000
3	Анхболдын Энхмэнд	88.11%	352,629,000
4	Довжидын Гансүх	88.11%	352,746,000
5	Бямбабаярын Баттүшиг	88.11%	352,629,000
6	Цэрэндагвын Мөнхлхагва	88.11%	352,629,000

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Д.ЭНХЗУЛ

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮД

О.ТЭМҮҮЖИН
Ю.ДҮГЭРМАА

ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫГ ТАНИЛЦУУЛАХ:

Хурлын дарга Б.Баттүшиг танилцуулав.

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалт, Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны зардлын төсөв батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны 26/01 ЦУХ тоот тогтоол, 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг Нэгдүгээр хавсралтад заасны дагуу баталсугай.
- Хоёр. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, цалин хөлс, урамшууллыг үр дүнг харгалзаж олгож байхыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.1, 7.18, 7.19 дэх заалт, 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах гишүүдийн бүрэлдэхүүнээр улируулан сонгосугай.
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:
Төмөрбаатарын Болд
Чулуунбаатарын Нямдорж
Жадамбын Эрдэнэбат
Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:
Батчулууны Анхболд
Анхболдын Энхмэнд
Батчулууны Баянжаргал
Довжидын Гансүх
Бямбабаярын Баттүшиг
Цэрэндагвын Мөнхлхагва
- Хоёр. Компанийн дүрмийн 7.19-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил буюу дараа жилийн компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.
- Гурав. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад дүрэм журмуудыг мөрдөж ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Хурлын дарга **Б.Баттүшиг**: Булигаар ХК-ийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.
Хурал 14 цаг 35 минутад өндөрлөв.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:



Б.БАТТҮШИГ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн,

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧИГ:

Г.Цээпилжид

Г.ЦЭЭПИЛЖИД